



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот


┌ Дэд хөтөлбөр батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн “Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбаямба/-д үүрэг болгосугай..

ДАРГА



С.АМАРСАЙХАН

1110100294

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын
13-ны өдрийн 88 дугаар тогтоолын хавсралт



“НИЙСЛЭЛД БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ 2017-2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР”

Нэг. Ерөнхий мэдээлэл

Биеийн тамир, спортын тухай хууль, Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Монгол Улсын Их Хурлын 2008 оны Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай 12, 2009 оны Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай 95, 2010 оны Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай 48, 2016 оны Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 45 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны Үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 3/08 дугаар тогтоол зэрэг бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан “Нийслэлд Биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг боловсруулав.

Монгол орны хүн амын нас баралтын шалтгааны дотор сүүлийн 10 жилд хөдөлгөөний хомстол, хоол хүнсний зохисгүй хэрэглээ зэргээс үүдэлтэй халдварт бус өвчин давамгайлж, нэмэгдэх хандлагатай байна.

Манай улсад ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийсэн шаталсан судалгаагаар 15-64 насны хүн амын 10 хүн тутмын 9-д нь халдварт бус өвчний нийтлэг эрсдэлийн аль нэг нь илэрсэн, 5 хүн тутмын нэгд нь 3 ба түүнээс олон эрсдэлт хүчин зүйлс хавсран тохиолдож, 45 ба түүнээс дээш насны 2 эрэгтэй хүн тутмын нэг нь халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр, 15-64 насны хүн амын 31.6 хувь нь илүүдэл жинтэй буюу таргалалттай байна.

Хүүхэд, өсвөр үеийнхний 80.2 хувь нь бие бялдрын хөгжлийн хувьд “С” буюу түүнээс доош үнэлгээтэй өөрөөр хэлбэл тухайн насныхаа бие бялдрын хөгжлийн түвшинд хүрэхгүй, 15-34 насны эрэгтэйчүүдийн 87.7-89.1 хувь нь хөдөлгөөний идэвх багатай бие бялдрын хөгжил-чийрэгжилтээрээ байвал зохих түвшинд хүрэхгүй гэсэн үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод олон улсын чанартай томоохон арга хэмжээг зохион байгуулах орчин үеийн шаардлага хангасан биеийн тамир, спортын барилга байгууламж, орон сууц, гэр хорооллын дунд иргэдийн амрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх гүйлт, алхалт, дугуйгаар хичээллэх зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг бүхий биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн талбай дутмаг хэвээр, ерөнхий боловсролын сургуулийн спортын заал, танхим ачааллаа даахгүй нэг цагт 2-3 анги буюу 120-150 хүүхэд нэгэн зэрэг хичээллэж байна.

Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын бүтэц, орон тоог тухайн дүүргийн хүн амын тоо, байршилтай уялдуулан зохион байгуулж, орон нутгийн онцлогт тохирсон биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлон материаллаг баазыг бэхжүүлэх, биеийн тамир, спортын үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа төсөв, зардлыг өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх шаардлагатайг бодит байдал харуулж байна.

Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Дэд хөтөлбөрийн зорилго

Иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлж, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн биеийн тамир, спортын ажил үйлчилгээ, орчин нөхцөлийг сайжруулахад энэхүү дэд хөтөлбөрийн гол зорилго оршино.

2.2. Дэд хөтөлбөрийн зорилт

2.2.1. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах;

2.2.2. Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.2.3. Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын залгамж халааг бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох;

2.2.4. Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох;

2.3. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2017-2020 он хүртэл хэрэгжүүлнэ.

Гурав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын спортын цогцолборын барилгыг барьж дуусгана.

3.1.2. Олон улсын шаардлагад нийцсэн цэнгэлдэх хүрээлэн, усан спортын төв зэрэг биеийн тамир, спортын барилга байгууламжуудыг шинээр барьж байгуулах асуудлыг бодлогоор дэмжиж, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, төсөвт тусган гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.1.3. Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бүхий биеийн тамирын болон тоглоомын талбай, спортын төрөлжсөн заал танхимыг нийслэлийн дүүрэг, хороо, гудамж, хорооллуудын дунд барьж байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

3.1.4. Биеийн тамир, спортын зориулалттай барилга байгууламжийн судалгааг хийж, ашиглалтыг сайжруулна.

3.1.5. Ерөнхий боловсрол, Их дээд сургуулийн орчинд чийрэгжүүлэх фитнес төв байгуулах ажлыг дэмжиж, Дүүрэг, Хороо, Хэсгийн иргэд оршин суугчдыг идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэх боломж нөхцөлийг нэмэгдүүлнэ.

3.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудад биеийн тамирын хамтлаг байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

3.2.2. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган аялал, алхалт, гүйлт, иог, фитнес болон оюуны спортын төрлүүдээр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлж ажиллана.

3.2.3. Биеийн тамир, спортын ажил үйлчилгээ, барилга байгууламж, зам талбайг барьж байгуулах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал санаачилга, оролцоог дэмжинэ.

3.2.4. Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, сурталчлах ажлыг нутгийн болон төр захиргааны байгууллагуудаас дэмжих, нийгмийн бүлгүүдийг тэгш хамруулах, нийтийг хамарсан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.5.Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжил, соёлыг дээшлүүлэх, тэднийг биеийн тамирын хичээл, секц, дугуйланд тогтмол, тасралтгүй хамрагдан хичээллэх нөхцөл боломж, заал танхим, хэрэглэл материал, техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.6.Биеийн тамир, спортын талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

3.3. Гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1. Нийслэлд үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын залгамж халааг бэлтгэх эрх зүйн болон санхүүгийн таатай орчинг бүрдүүлнэ.

3.3.2.Багийн спортоор дамжуулан хүүхэд, залуучуудын авьяас, ур чадварыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлнэ.

3.3.3.Нийслэлд олон улс, тив, дэлхийн чанартай биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахыг дэмжинэ.

3.3.4.Үндэсний спорт, тоглоом наадгайн төрлүүдийг хөгжүүлэх, өсвөрийн хүүхэд багачуудад өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.1.Биеийн тамир, спортын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, материаллаг бааз, эрх зүй, хөрөнгө санхүүгийн орчинг сайжруулна.

3.4.2.Биеийн тамир, спортын сурталчилгаа мэдээлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад, дотоодын байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.4.3.Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээг эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг дэмжих, урамшуулах тогтолцоог боловсронгуй болгоно.

3.4.4.Нийслэлд биеийн тамир, спортын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг эхлүүлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас биеийн тамир, спортын үйлчилгээнд дэмжлэг авах боломжийг бүрдүүлнэ.

Дөрөв. Дэд хөтөлбөрийн үр нөлөө бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

Үр нөлөө: Нийслэлд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл, олон улс, тив, дэлхийн чанартай томоохон спортын арга хэмжээ зохион байгуулах боломж бүрдэн биеийн тамир, спортын байгууллагуудын чадамж сайжирч иргэдэд үзүүлэх үйлчилгээ, арга хэмжээ чанаржин, биеийн тамир, спортод хандах бүх нийтийн хандлага сайжирна.

Бүтээгдэхүүн:Нийслэлд орчин үеийн шаардлага, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын барилга байгууламжууд баригдаж, биеийн тамир, спортын үйлчилгээ, арга хэмжээний тоо нэмэгдэн биеийн тамир, спортыг дэмжигч, оролцогч байгууллага, иргэдийн тоо, эзлэх хувь өснө.

Шалгуур үзүүлэлт:Нийслэлд шинээр байгуулагдсан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн талбай, заал танхим, барилга байгууламжийн тоо, тэдгээрийг барьж байгуулах ажлын гүйцэтгэлийн явц, хувь;

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2016 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хэрэгжилтийн явц болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэм- жих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	
			Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
1	Шинээр баригдсан спортын барилга байгууламж	Тоо	Сонгинохайрхан дүүргийн БТС-ын цогцолбор -1	2020	6
2	Шинээр байгуулагдсан дугуйн зам	Км	-	2020	10 - 12
3	Үйл ажиллагаа нь тогтмолжсон биеийн тамирын хамтлаг	Тоо	647 хамтлаг	2020	700
4	Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо, хувь	Тоо, хувь	673.540 хүн буюу Нийслэлийн хүн амын 49%	2020	680.000 - 700.000 хүн буюу Нийслэлийн хүн амын 50%, түүнээс дээш
5	Бие бялдрын сорилд хамрагдсан иргэдийн тоо, хувь	Тоо	132.081 хүн	2020	200.000 хүн
6	Өсвөрийн шигшээ багт байгуулах спортын төрөл, тамирчдын тоо	Тоо	Спортын төрөл - 18, тамирчин - 1030, дасгалжуулагч - 68	2020	Спортын төрөл 18-20, тамирчин - 1200
7	Ерөнхий боловсролын сургууль, спортын холбоо, клубүүдийг түшиглэн сургалт явуулж байгаа секц дугуйлан, түүнд хичээллэгч иргэдийн тоо	Тоо	Секц - 394, Хичээллэгчид - 16999	2020	Секц – 400 - 420 18000 - 20000
8	Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажилд хөрөнгө оруулж, хамтарч ажилласан байгууллага, иргэдийн тоо	Тоо	-	2020	6-8
9	Нийслэлийн нэг иргэнд биеийн тамир, спортын ажил үйлчилгээг хүргэхэд оногдох зардал	Тоо	280 төгрөг	2020	300 - 400 төгрөг

Тав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Дэд хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

а/ Монгол Улсын нэгдсэн төсөв, Нийслэлийн төсөв

б/ Олон улсын болон гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

в/ Биеийн тамир, спортыг хөгжүүлэх сангийн хөрөнгө

г/ Бусад

Зургаа. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-үнэлгээний төлөвлөгөө

6.1. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

6.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан хоёр жил тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ

6.3. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

---oOo---